



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/149

Улаанбаатар хот

“Геодези-2025” улсын олимпиад
зохион байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын харилцааны ажилтны өдрийг тохиолдуулан Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Монголын геодези, фотограмметр, зураг зүйн холбоо төрийн бус байгууллагатай хамтран “Геодези-2025” улсын олимпиадыг 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсугай.

2. “Геодези-2025” улсын олимпиадыг өндөр түвшинд зохион байгуулахыг Геодези, зураг зүйн хэлтэс (Д.Мөнхцэцэг)-т даалгасугай.

3. Олимпиадад амжилт үзүүлсэн багш, оюутнуудад “Дэлхийн улсуудын атлас” 20 ширхэг, “Улаанбаатар хотын атлас” монгол, англи 30 ширхэг нийт 50 (тавь) ширхэгийг олгохыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (Г.Халиунбигэр)-т зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын газар (Б.Энхболд)-т даалгасугай.

ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ

1525010537

тушаал
А/149